

Хичээл №12

# Төсөв





Төсөв нь орлого,  
зарлага, хуримтлалаас  
бүрдэнэ.



Хүүхдүүд бидний хувьд  
аав, ээж, эмээ, өвөөгийн  
өгсөн мөнгө, эсхүл  
улсаас олгодог  
Хүүхдийн мөнгийг  
орлого гэж хэлж болно.

Мөн хүүхдүүд өөрийнхөө насанд  
тохирсон ажлыг хийж  
гүйцэтгэснийхээ хариуд авсан, эсхүл  
эд зүйлээ борлуулж олж авсан мөнгө  
ч гэсэн орлого юм.




Хөрш эмээгийн  
ногооны талбай,  
цэцгийг нь усалсны  
хариуд эмээ бидэнд  
мөнгө өгсөн.





Харин зарлага гэдэг нь ямар нэг эд зүйлийг худалдаж авахад эсхүл үйл ажиллагаанд зориулан зарцуулж буй мөнгө юм.




Би аавын өгсөн мөнгийг цуглуулж байгаад өөртөө шинэ дугуй авна.



Харин би хөрш эмээгийн ногооны талбайд ажиллаж олсон мөнгөнөөсөө комик ном авсан.



Хүүхдүүд ээ,  
мөнгөө олсон  
хэмжээгээр нь  
зарцуулж, үрэлгүй  
хуримтлуулаарай!



Ирээдүйд ашиглахаар мөнгөө  
хадгалж, цуглуулахыг хуримтлал  
ГЭНЭ.

Би аав, ээж, эмээ, өвөөгийнхөө  
өгсөн мөнгөнөөс тодорхой  
хэсгийг нь хуримтлалдаа хийдэг.  
Том болоод энэ хуримтлалаа  
дэлхийг тойрох аялалдаа  
зарцуулна.





Орлого, зарлага, хуримтлалаа бүртгэж, түүнийгээ хэрхэн зарцуулах төлөвлөгөөг ТӨСӨВ гэнэ.

Мөнгөө зөв зүйлд зарцуулж, хуримтлал үүсгэхийн тулд төсөв зохиож, төсвийн дагуу зарцуулах хэрэгтэй.

Миний 6-р сарын төсөв	
<b>Орлого:</b>	
- Аав, ээжийн өгсөн мөнгө	- 20,000₮
- Хөрш эмээгийн ногооны талбайд ажилласан цалин	- 20,000₮
<b>Нийт орлого - 40,000₮</b>	
<b>Зарлага:</b>	
- Ном	- 8,000₮
- Хоол	- 10,000₮
- Найзуудтайгаа кино үзэх	- 5,000₮
<b>Нийт зарлага - 23,000₮</b>	
<b>Хуримтлал:</b>	
- Хадгаламжийн дансанд	- 15,000₮
- Мөнгөний гахайнд	- 2,000₮





За хүүхдүүд ээ! Бүгдээрээ төсвийн талаар мэддэг боллоо. Одоо харин ангийн орлого, зарлагаа тооцоолж, аяллын зардалдаа хэр хэмжээний мөнгийг зарцуулахыг тооцъё.

Манай ангийн орлого бидний цуглуулсан хуримтлалын мөнгөнөөс бүрдэнэ.

Ингээд бид ангийн төсөвтэй уялдуулан аяллаар явах зардлаа ч төлөвлөлөө.

### Ангийн аяллын төсөв

Аялах чиглэл: Төрийн ордон

Ангийн орлого - 300.000₮  
/сурагчдын цуглуулсан мөнгө/

#### Аяллын зардал:

Автобусны зардал - 100.000₮

Төрийн ордонтой танилцах аяллын төлбөр - 0₮

Ус - 25.000₮

Сэндвич - 50.000₮

Нийт - 175.000₮











ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Хувь хүн, анги, гэр бүлийн төсөв байдаг шиг улсад бас төсөв бий.  
Улсын төсөв гэж манай улс тухайн жил олсон орлогоо юунд зарцуулах, хэдийг нь дараа хэрэглэхээр үлдээхийг зохицуулсан төлөвлөгөөг хэлнэ.

Улсын төсвийг  
Улсын Их Хурал  
батална.





## ТҮЛХҮҮР ҮГ



Найзууд аа! Эдгээр түлхүүр үгийг өдөр тутмын амьдралдаа ашиглаарай. Мөн аав, ээждээ төсвийн талаар юу мэдсэнээ ярьж өгөөрэй.

МӨНГӨ

ОРЛОГО

ТӨГРӨГ

ТӨСӨВ

ХУРИМТЛАЛ

ЗАРЛАГА



## ДАСГАЛ АЖИЛ

“Миний төсөв” дасгалын хуудсан дээр өөрийн сарын төсвийг төлөвлөн бичээрэй.



## ХЯНАЛТЫН АСУУЛТ

1. Орлого гэж юу вэ? Чиний орлого хэрхэн бүрддэг вэ?
2. Зарлага гэж юу вэ? Юу, юунд зарцуулагддаг вэ?
3. Чамд хуримтлал байдаг уу? Хуримтлалыг яагаад бий болгох ёстой вэ?
4. Төсөв гэж юу вэ? Төсөв зохиохын ач холбогдлыг тодорхойлно уу.